

# ГҮТГЭХ, ДОРОМЖЛОХ ГЭМТ ХЭРЭГ

Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны  
дарга Б.Батзориг

### Алдар хүнд

бусдаас өөрийнх нь талаар өгсөн үнэлгээнд тулгуурлан өөртөө өгсөн тухайн хүний үнэлэмжийг ойлгоно.

### Нэр төр

тухайн хүний хувийн болон ёс зүй, түүнчлэн ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшингийн талаар бусдаас өгч буй үнэлэмж

## Доромжлох

## Гүтгэх

Бусдын нэр төр, алдар хүндэд халдах шууд санаатай

Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой шууд санаатай

нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон ёс суртахууны шаардлагын хэм хэмжээ, үндэсний зан заншил, уламжлалд харшилсан, тухайн хүний нэр төр, алдар хүндийг санаатай гутаасан үйлдлийг хэлнэ.

өш хонзон санах, үзэн ядах, уур хорслоо тайлах, атаархах, эр эмийн хардлага зэрэг атгаг санаагаа хэрэгжүүлэх гэсэн хувийн сэдэлт

## Доромжлох

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан зэргээр илэрнэ.

## Гүтгэх

Илт болоогүй зүйлийг болсон, болсон зүйлийг болоогүй мэтээр илэрхийлсэн  
**“...худал гүжирдлэг...”**  
гэдэгт илт худал мэдээлэл, баримт сэлтийг тараасан.

## Доромжлох

“...**олон нийт**...” буюу хоёр буюу түүнээс олон хүний дэргэд доромжилсон байхыг шаардахгүй бөгөөд бусдын нэр төр, алдар хүндийг нэг хүний ч дэргэд гутаасан байж болно

## Гүтгэх

“...**нийтэд тараасан**...” гэж худал гүжирдлэгийг нэг буюу түүнээс дээш хүнд түгээсэн

**“...хүнд хор уршиг учирсан...”** гэдэгт гүтгэгдсэн этгээд эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнд холбогдон мөрдөн шалгагдсан, цагдан хоригдсон, ял шийтгүүлсэн, ял эдэлсэн, түүнчлэн эд хөрөнгийн хувьд хохирол учирсан, захиргааны санаачлагаар ажлаас халагдсан, гэрлэлтийг цуцалсан, өөрөө болон түүний гэр бүлийн гишүүд нь сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, бие эрхтэнд нь хүнд гэмтэл учирсан буюу амь нас хохирсон

**Хүндрүүлэх нөхцөл байдал**

- Хүний хувийн нууцыг задруулах замаар доромжилсон бол нийлмэл гэмт хэрэг гэж үзэж, Эрүүгийн хуулийн 110, 136 дугаар зүйлээр давхар зүйлчилнэ.
- Доромжлох болон гүтгэх гэмт хэргийг үйлдэхдээ бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлсэн бол Эрүүгийн хуулийн 110, 111, 149 дүгээр зүйлээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
- Доромжлох гэмт хэрэг нь тодорхой хүний эсрэг чиглэсэн, түүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой байдаг бол танхайрах гэмт хэрэг нь олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн байдгаараа ялгагдана.

- Доромжлох нь тодорхой албан тушаал эрхэлж байгаатай нь буюу хууль тогтоомжоор хүлээсэн үүрэгтэй нь холбогдуулах бус зөвхөн хувь хүний эсрэг чиглэсэн байдаг шинжээрээ Эрүүгийн хуулийн 231 дүгээр зүйлд заасан “Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох” гэмт хэргээс ялгагдана.
- Гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь хүний нэр төр, алдар хүндийг гутаах гэсэн шууд санаатай байдаг бол Эрүүгийн хуулийн 252 дугаар зүйлд заасан “Зориуд худал мэдээлэх” гэмт хэрэг үйлдсэн этгээд нь бусдад хууль бусаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилготой байдгаар ялгагдана.

- Доромжлох нь бодит байдалд нийцсэн байж болдгоороо гүтгэх гэмт хэргээс ялгагдах боловч уг үйлдлийг хийснээр хүний нэр төр, алдар хүнд гутаагддаг учир гэмт хэрэгт тооцогдоно.
- Доромжилсон, эсхүл гүтгэсэн үйлдэл нь энэ хоёр гэмт хэргийн аль алиных нь шинжийг агуулж байгаа бол нийлмэл гэмт хэрэг гэж үзэж, давхар зүйлчилнэ.
- Доромжлох гэмт хэргийн объект нь тухайн хүний нэр төр, алдар хүнд байдаг тул хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаасан аливаа үйлдлийг доромжлох гэмт хэрэгт тооцохгүй.